


Vysockina Region



Таныг
хамгаалах дүрэм журам
Височина аймагт гадаад иргэдийн
аюулгүй амьдрал

| | |
|--|----|
| Яаралтай тусламж дуудах утасны жагсаалт | 4 |
| Гадаад иргэний эрх, үүрэг | 5 |
| Хөдөлмөр эрхлэлт | 7 |
| Орон сууц | 11 |
| Боловсрол | 13 |
| Амралт чөлөөт цаг | 16 |
| Аюулгүй байдал | 18 |
| Эрүүл мэндийн хэсэг | 22 |
| Зам тээвэр | 24 |
| Чех улсад оршин суух 10 дүрэм | 25 |
| Jihlava хотод хамааралтай албан байгууллагуудтай холбогдох дэлгэрэнгүй жагсаалт | 26 |
| Třebíč хотод хамааралтай албан байгууллагуудтай холбогдох дэлгэрэнгүй жагсаалт | 28 |
| Pelhřimov хотод хамааралтай албан байгууллагуудтай холбогдох дэлгэрэнгүй жагсаалт | 30 |
| Žďár nad Sázavou хотод хамааралтай албан байгууллагуудтай холбогдох дэлгэрэнгүй жагсаалт | 32 |
| Havlíčkův Brod хотод хамааралтай албан байгууллагуудтай холбогдох дэлгэрэнгүй жагсаалт | 34 |

1. Товч танилцуулга



Энэхүү товхимол нь бүх орны гадаад иргэдэд зориулан хийгдсэн болно. Европын Холбоонд хамрагдаж буй гадаад иргэд, Европын Холбооноос бусад орны гадаад иргэд тус бүр өөр өөр эрх, үүрэгтэй байдаг. Таны эрх үүрэг, Чех улсад ямар төрлийн визээр орж ирснээс тань хамаарна. Тийм учраас та өөрийн оршин сууж байгаа визнийхээ талаар болон түүнтэй холбоотой эрх, үүрэгтэйгээ танилцан нарийн судлахыг зөвлөж байна. Товхимол нь дотроо Европын Холбооны иргэд, Европын Холбооноос бусад орны иргэдэд зориулсан мэдээлэл, болон нийтлэг гэсэн 3 хэсэгт ангилагдсан байгаа. Товхимол нь ерөнхий журам, мэдээллийн гэсэн 2 агуулгатай. Тодорхой асуудлыг шийдэхдээ түүнтэй холбогдох албан байгууллагад хандах нь зүйтэй. Товхимолын төгсгөлөөс та албан байгууллагуудын жагсаалтыг олж хараарай.

Височина аймагт бүртгэлтэй гадаадын бүх иргэд нийгмийн ба хууль зүйн зөвлөгөөг Гадаад иргэдийн дасан зохицох тусламжийн төвөөс үнэ төлбөргүй авах боломжтой.

Оршин суухтай холбоотой асуудлын талаар (оршин суух хугацааг сунгах, оршин суух зорилгоо өөрчлөх гэх мэт) тухайн цаг үеийн шинэчлэгдсэн мэдээллүүдийг Дотоод хэргийн яамны вэб сайтаас авах боломжтой.

www.mvcr.cz/docDetail.aspx?docid=21667282&doctype=ART

QR код татан суулах програмын /апликац/ заавар товхимлын сүүлийн хуудаснаас хараарай.



2. Яаралтай тусламж дуудах утасны жагсаалт:



 Эмнэлгийн түргэн тусламж


155

 Гал түймэртэй тэмцэх газар

150

 Цагдаагийн газар

158

 Та мөн Европын нэгдсэн шуурхай тусламжийн албаны 112 дугаарт холбогдож болно.

112



Танд тусламж авах шаардлагатай үед, яаралтай тусламж үзүүлэх эрх бүхий албан байгууллагууд байдгийг та мэдэх үү? Эдгээр дугаарууд үнэ төлбөргүй бөгөөд урвуулан ашиглах нь хууль бус ба торгууль ногдуулах хүртэл арга хэмжээ авна. Түргэн тусламжийн утас нь 24 цагаар таны дуудлагыг хүлээн авах болно.

Ямар үндсэн мэдээлэл өгөх вэ?



Дуудлагын үеэр дараах үндсэн мэдээллийг өгнө үү:

- **Хэн залгаж байгаа?**
- **Таны хаяг байршил?**
- **Юу болсон талаарх?**

3. Гадаад иргэний эрх, үүрэг

Үндсэн үүрэг

| Европын Холбооны иргэд | Европын Холбооны бус иргэд |
|---|--|
| Овог нэрэнд өөрчлөлт орсон тохиолдол (гэрлэлтээ батлуулах, цуцлуулах) гадаад паспорт болон иргэний үнэмлэхийн баримт бичигт өөрчлөлт гарсан тохиолдолд, ажлын 15 хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй. | Овог нэрэнд өөрчлөлт орсон тохиолдол (гэрлэлтээ батлуулах, цуцлуулах, бэлэвсэрсэн) гадаад паспорт болон оршин суух картанд өөрчлөлт гарсан тохиолдолд, ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх үүрэгтэй. |
| Чех улсад 30 ба түүнээс дээш хоногийн хугацаатай ирсэн тохиолдолд, оршин сууж буй гэрийн хаягаа ирснээсээ хойш ажлын 30 хоногийн дотор мэдэгдэх ёстой. Хэрэв таны хаягыг түрээслэгч эзэн тань мэдэгдсэн бол энэ үүргээс чөлөөлөгдөнө. | Чех улсад ирснээс хойш ажлын 3 өдрийн дотор оршин суух хаягаа мэдэгдэх ёстой. Хэрэв таны хаягыг түрээслэгч эзэн тань мэдэгдсэн бол энэ үүргээс чөлөөлөгдөнө. |

Нийтлэг хэсэг:

Европын Холбооны ба бусад орны иргэдийн үүрэг хариуцлага

- Оршин сууж буй хаяг нь дээр 180 өдрөөс дээш хугацаагаар өөрчлөлт орсон тохиолдолд, ажлын 30 хоног дотор мэдэгдэх үүрэгтэй.
- Оршин суух картаа (ягаан карт) хаяж гээгдүүлэх, гэмтэж эвдрэх, ямар нэгэн байдлаар хулгайд алдах тохиолдолд уг асуудлаа ажлын 3 хоног дотор мэдэгдэх үүрэгтэй.
- Мөн гадаад паспортаа хаяж гээгдүүлэх, хулгайд алдах тохиолдолд, цагдаагийн газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- Чех улсад байх хугацаандаа хуулийн дагуу оршин суух зөвшөөрлийн нотлогоо (ягаан карт, эрүүл мэндийн даатгал, E паспорт буй бидний хэлж сурснаар гадаад паспорт) бүхий холбогдох бичиг баримтыг байнга биендээ авч явах үүрэгтэй.
- Та Чех улсын хууль дүрэм, хуулийн заалтуудыг мэдэх, түүнийг даган мөрдөх үүрэгтэй.
- Чех улсын хот болгонд мөрдөх дүрэм журам нь адилгүй байдаг. Тиймээс та байгаа хотынхоо тогтоол дүрмийг сайтар судлаж, түүний дагуу даган мөрдөх үүрэгтэй (жишээлбэл: олон нийтийн газар архи согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох гэх мэт). Захиргаа албан байгууллагад бүрдүүлэн өгөх баримт бичгүүд, албан ёсны шүүхийн хэлмэрчээр (дугуй тамга) орчуулагдсан байх ёстой.

Нийт бүртгэгдсэн шүүхийн хэлмэрчдийн жагсаалтыг онлайн вэбсайтаар орж харна уу:



[datalot.justice.cz/justice/repznatl.nsf/\\$\\$SearchForm?OpenForm&Seq=1](http://datalot.justice.cz/justice/repznatl.nsf/$$SearchForm?OpenForm&Seq=1)

QR код татан суулах програмын /апликац/ заавар товхимлын сүүлийн хуудаснаас хараарай.

Гадаад иргэний эдлэх эрх

- Хүний үндсэн эрх, эрх чөлөө – хувь хүний эрх чөлөө, нэр төрөө хадгалах, албадан хөдөлмөр эрхлэхээс татгалзах эрхтэй.
- Ялгаварлан гадуурхах, хөдөлмөрийн эрх тэгш бус нөхцлөөс хамгаалах эрхтэй.
- Хувь хүний амьдрал, нэр төр, эрүүл мэнд, хувийн шинж чанараа хамгаалах эрхтэй.
- Иргэн хүний эрх, үүрэг хуулийн заалтаар тогтоогдсон байдаг ба хэрэв та эрх үүргийнхээ тал дээр эргэлзэж байвал холбогдох байгууллагад хандана уу.

Хууль бусаар оршин сууж буй Европын холбооноос бусад орны иргэд



Чех улсад нэвтрэн орохын тулд богино хугацааны эсвэл удаан хугацааны визтэй байх шаардлагатай бөгөөд удаан хугацааны оршин суух зөвшөөрөл эсвэл байнгын оршин суух зөвшөөрөлтэй байх ёстой (эсвэл оршин суух зөвшөөрлөө D/VR визээр авсан байх). Визгүй зорчих зөвшөөрөлд хамрагдсан орны иргэдүүд Чех улсад визгүй нэвтрэн орох боломжтой. Хууль бусаар нэвтрэн орох нь дээрх дурьдсан визийн зөвшөөрлийн гадуур Чех улсад нэвтрэхийг хэлнэ. Дээрх оршин суух зөвшөөрөлд олон улсын хамгаалалтын (цагаачлал, нэмэлт хамгаалалт) талаар тусгаагүй. Яагаад гэвэл Олон улсын хамгаалалтын заалт нь тусгайлсан дүрэм журамтай байдаг.

Оршин суух визний төрлөөс үл нийцэх нь (жишээ нь: хэрэв гадаадын иргэн Чех улсад хөдөлмөрийн гэрээтэй ажлын визээр нэвтрэн орж ирсэн тохиолдолд хувиараа бизнес эрхлэх боломжгүй) хууль бусаар оршин суух, визний зорилго зөрчигдсөнд тооцно. Дээрх тохиолдол иргэдийн дунд олширсон бөгөөд уг асуудлаас шалтгаалж оршин суух эрхээ цуцлуулах нь их болсон.

Чех улсад оршин суух зорилгоо өөрчлөхөд тодорхой шаардлага нөхцөл хангасны дараа визний төрлийг өөрчлөх өргөдөл гаргах эрхтэй. Хэрэв танд визний төрөл өөрчлөн солих тал дээр тусламж хэрэгтэй бол үнэ төлбөргүй зөвлөгөө OAMP – Дотоод хэргийн яамны Цагаач, шилжин сууршилтын бодлогын газраас аваарай. Холбоо барих хаягуудыг товхимлын сүүлийн хуудаснаас хараарай.

Оршин суух зөвшөөрөл нотлосон баримтны хугацаа дууссан, хуурамч бичиг баримттай эсвэл оршин суух зөвшөөрөлгүй гадаад иргэд мөн адил хууль бусаар оршин сууж буйд тооцогдоно. Энэ тохиолдолд цагдаагийн газар дараах арга хэмжээ авна:

- 48 цагийн дотор саатуулан барих
- Бичиг баримт шалгах, хурууны хээ авах
- Цагдаагийн байгууллагаас албадан гаргах шийдвэр гарах (Чех улсын нутаг дэвсгэрээс гарах) эсвэл гадаад иргэдийг саатуулан байрлуулах газарт шилжүүлэх (хамгаалалттай хорих газар)



Танд зөвлөмж хэрэгтэй юу? Дараах албан байгууллагуудад хандаарай (холбоо барих хаягыг товхимолын сүүлийн хуудаснаас харж болно)

OAMP – Височина аймгийн харьяа Дотоод хэргийн яамны Цагаачлал, шилжин сууршилтын бодлогын газар

Чех улсын цагдаагийн газар, Гадаадын харьяатын асуудал эрхэлсэн цагдаагийн байгууллага

Височина аймгийн харьяа Гадаад иргэдийн дасан зохицох тусламжийн төв

4. Хөдөлмөр эрхлэлт



Чех улсад гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг – гадаадын иргэн Чех улсад оршин суух тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль, хөдөлмөрийн хуулиар зохицуулна.

Ажилтан хүний эрх ба үүргийг хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулдаг. Хэрэв танд хөдөлмөр эрхлэх гэрээ болон гэрээн дотор орсон заалтуудаа ойлгохгүй тохиолдол гарвал, орчуулганд өгөх юм уу Гадаад иргэдийн дасан зохицох тусламжийн төвд хандах хэрэгтэй.

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бүх шийдвэр ба нэмэлт заалтууд бичгээр байх ёстой. Аман харилцаагаар тохирсон гэрээ хүчингүй бөгөөд Чех улсын хуульд зөвшөөрөгдөөгүй. Баримт бичгийн нэг хувь ажилтанд, нөгөө хувь нь ажил олгогчид үлдэх ёстой.

Хөдөлмөр эрхлэлтийн талаарх үндсэн ойлголтууд



| | |
|--|---|
| Ажлын цаг | Нэг хүний долоо хоногт гүйцэтгэх ажлын бүтэн цагийн дээд хэмжээ нь 40 цаг. |
| Илүү цагийн ажил | Долоо хоногт дээд хэмжээ нь 8 цаг, жилд 150 цаг (хоорондын тохиролцооны үндсэн дээр түүнээс илүү цаг хийж болно). |
| Ээлжийн амралт, чөлөө | Доод тал нь жилд 4 долоо хоног (ажил олгогч танд түүнээс дээш амралт олгож болох ба түүнээс доош байх ёсгүй). |
| Туршилтын хугацаа | 0-3 сарын хугацаатай, албан тушаал дээш ажилтанд 6 сараас дээш хугацаатай. |
| Хөдөлмөрийн гэрээ цуцлагдах хугацаа | Хуулийн дагуу 2 сарын хугацаатай байдаг бөгөөд хоорондын тохиролцооны үндсэн дээр өөрөөр тогтоож болно. |
| Цалингийн доод хэмжээ | Ажил олгогчоос ажилтанд олгож болох цалингийн доод хэмжээ 2020 оны байдлаар бүтэн цагаар ажилладаг орон тооны ажилтны цалингийн доод хэмжээ 14600 Чех крон байна. |

Заавал олгогдох нэмэлт цалин



| | |
|--------------------------------------|-----------------------------|
| Шөнийн ажил (22:00 – 6:00) | цагийн дундаж хөлсний 10 % |
| Илүү цагийн ажил | цагийн дундаж хөлсний 25 % |
| Баярын өдөр | цагийн дундаж хөлсний 100 % |
| Хагас, бүтэнсайны амралт өдөр | цагийн дундаж хөлсний 10 % |

Засгийн газрын тогтоолын дагуу хөдөлмөрийн доод хэмжээ өөрчлөгдөж болох тул шинэчилсэн мэдээг вэбсайтаар орж авна уу:

<https://www.mpsv.cz/web/en>

QR код татан суулгах програмын /апликац/ заавар товхимлын сүүлийн хуудаснаас хараарай.



Хөдөлмөрийн гэрээ ба түүнтэй холбоотой зүйлүүд

Хөдөлмөрийн гэрээ нь тодорхой хугацаатай, тодорхой бус хугацаатай гэсэн 2 төрөл байдаг. Хугацаатай хөдөлмөрийн гэрээ тохиролцсон хугацаа дууссаны дараа цуцлагдана.

Гэрээний хугацааг дээд тал нь 2 удаа сунгаж болох ба түүнээс хойш хугацаагүй гэрээ болж хувирдаг

(1 хөдөлмөр эрхлэх тохиролцоо = 1 хөдөлмөрийн гэрээ + 2 удаа сунгах)

Туршилтын хугацаа нь ажилд орсон анхны өдрөөс эхэлдэг. Туршилтын хугацаанд ажил олгогч болон ажилтны зүгээс ямар нэгэн шалтгаангүйгээр хөдөлмөрийн гэрээ цуцлаж болно.

Хэрэв та хөдөлмөрийн гэрээгээ цуцлуулахаар шийдсэн бол, хөдөлмөрийн гэрээ цуцлагдах хугацааг дуустал баримтлах ёстой. Гэрээ цуцлагдах хугацаа нь гэрээ цуцлуулах хүсэлт гаргасан өдрөөс хойш эхэлнэ. Хүсэлтээ албан бичгээр өгөх ёстой.

Хэрэв та өвчилсөн бол түр хугацааны хөдөлмөрлөх чадваргүй (DPN) эрхээ эдлэн чөлөө авч болно. Ийм тохиолдолд түр хугацаанд хөдөлмөр эрхлэх чадваргүйг батласан эмчийн бичгийг авч ирэх ёстой. Хэрэв та ажлын цагийн хугацаанд эмч дээр очих шаардлагатай бол, ажил олгогчоосоо зөвшөөрөл авах ёстой бөгөөд түүний дараа эмч дээр очсон баримт бичгээ өгөх хэрэгтэй. Ер нь бол эмч дээр очих цагаа ажлын бус цагаар төлөвлөх хэрэгтэй.

Ажил олгогчоосоо нэхэмжлэх ёстой зүйл бол цалингийн хуудас юм. Цалингийн хуудсыг танд сар болгон олгох үүрэгтэй. Хэрэв таныг ажлын газар чинь албан томилолтоор явуулсан тохиолдолд гарсан зардлын тооцооны баримтыг нэхэмжлэн хүсэх эрхтэй. Түүнд хуулийн дагуу хоол, замд гарсан зардал (бензин, онгоцны тийз, билет, бусад тасалбар...) байрлах орон сууц орно. Хоолны төлбөр зөвхөн ажлын цагаар орсон хугацаанд олгогддог.

Зардлын хэмжээ жил бүр өөрчлөгдөж болох тул шинэчилсэн мэдээг вэбсайтаар орж авна уу:



www.mfcr.cz/en/

QR код татан суулгах програмын /апликац/ заавар товхимлын сүүлийн хуудаснаас хараарай.

Хөдөлмөрийн гэрээ цуцлуулах нь

| | Туршилтын хугацаанд цуцлах нь | Ажил олгогчийн зүгээс цуцлах нь | Ажилтны зүгээс цуцлах нь | Хоорондын тохиролцоотой цуцлах нь |
|---------------------|--|--|--------------------------|-----------------------------------|
| Хэзээ? | Ажилд орсноос хойш 3 сарын дотор (хөдөлмөрийн гэрээнд заасан бол). | Хэзээ ч хамаагүй, гэхдээ зөвхөн хуульд заасан заалтын дагуу. | Хэзээ ч хамаагүй | Хэзээ ч хамаагүй |
| Тайлбар өгөх | Өгөхгүй | Өгнө | Өгөхгүй | Өгөхгүй |

| | Туршилтын хугацаанд цуцлах нь | Ажил олгогчийн зүгээс цуцлах нь | Ажилтны зүгээс цуцлах нь | Хоорондын тохиролцоотой цуцлах нь |
|------------------------------------|-------------------------------|---|---|--|
| Гэрээ цуцлагдах хугацаа | Байхгүй | Хөдөлмөрийн гэрээний дагуу ихэвчлэн 2 сарын хугацаатай байдаг. Цуцлалтын хугацаа нь сарын эхнээс тооцогдож эхэлдэг. | Хөдөлмөрийн гэрээний дагуу ихэвчлэн 2 сарын хугацаатай байдаг. Цуцлалтын хугацаа нь сарын эхнээс тооцогдож эхэлдэг. | Хугацаагүй, ажил олгогч ажилтан хоёрын хоорондоо тохирсон өдөр гэрээ цуцлагдана. |
| Халагдсаны тэтгэмж олгогдох | Олгогдохгүй | Нөхцөл хангасан тохиолдолд олгогдоно | Олгогдохгүй | Олгогдохгүй |

Хөдөлмөрийн гэрээ цуцлагдах тохиолдолд жирэмсэн, жирэмсний амралтанд орсон эмэгтэйчүүд болон эцэг эхийн амралтанд (0 – 4 настай хүүхдээ асарч буй эцэг эх) байгаа хүмүүс тусгай хуулийн хамгаалалтанд байдаг.

Хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссан тохиолдолд гэрээ цуцлагдана (гэрээнд заасан хугацаа). Хөдөлмөрийн тодорхой дуусах хугацаатай гэрээг уртасгах хүсэлтэй бол, гэрээний хугацаа дуусахаас өмнө гэрээ уртасгах хүсэлтээ ажил олгогчдоо гаргана уу.

Ойлгомжгүй байгаа гэрээ, албан ёсны баримт бичиг нь дээр гарын үсэг зурж болохгүй! Ажил олгогчийн зүгээс хөдөлмөрийн гэрээ цуцлах, туршилтын хугацаанд гэрээ цуцлагдах, эсвэл харилцан тохиролцсон гэрээ цуцлагдах үйлдлүүд Европын Холбооноос бусад орны гадаад иргэдийн Чех улсад оршин суух зөвшөөрлөө алдах шалтгаан болдог!

Хөдөлмөр эрхлэх гэрээ тань дууссан цааш сунгагдахгүй болсон тохиолдолд хөдөлмөрийн гэрчилгээ (potvrzení o zaměstnání) тэтгэврийн даатгалын хуудсаа (evidenční list důchodového pojištění) авахаа битгий мартаарай!

Европын холбооноос бусад орны гадаад иргэд – ажилтны үнэмлэх (zaměstnanecká karta)

Оршин суух эрхээс гадна хөдөлмөр эрхэлсний үндсэн дээр олгогдох удаан хугацааны оршин суух зөвшөөрөл нь 2 жилийн хугацаатай ба түүнээс цааш сунгагдаж болно. Ажилтны үнэмлэх нь тодорхой заасан ажил олгогч дээр баталгаатай ажлын байраар хангадаг. Та ажлаа солих ба ажил гүйцэтгэх удаан хугацаатай гэрээн дээр үндэслэн давхар ажил эрхлэж болно. Шинэ үүссэн хөдөлмөр эрхлэж буй байдлаа та Хөдөлмөрийн албаны бүртгэлд (úřad práce) бүртгүүлсэн байх ёстой. Хэрэв та Хөдөлмөр эрхлэлтийн албаны бүртгэлд бүртгүүлээгүй бол хууль бусаар хөдөлмөр эрхлэж байна!

www.uradprace.cz/web/en

QR код татан суулах програмын /апликац/ заавар товхимлын сүүлийн хуудаснаас хараарай.



Ажил олгогч болон Захиалагч тань гадаадын иргэд ажиллуулах зөвшөөрлөө Хөдөлмөрийн албаны бүртгэлд мөн адил бүртгүүлсэн байх ёстой.

Европын Холбооны гадаад иргэд

Та болон таны гэр бүлийн гишүүд Чех улсын зах зээл дээр чөлөөтэй, нээлттэй хөдөлмөр эрхлэх боломжтой. Чех улсын иргэдийн эрх, үүрэг танд адил үйлчлэх болно. Таны хөдөлмөр эрхлэж эхэлсэн тухай ажил олгогч тань Хөдөлмөр эрхлэлтийн албанд мэдэгдэн бүртгүүлнэ.

Сул ажлын байрны зарыг вэбсайтаар орж харна уу:

www.uradprace.cz, www.jobs.cz, www.prace.cz.

Ажил дээрх үүрэг хариуцлага



- Та ажил олгогчийн дотоод журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.
- Ажил дээр гарч болох ослоос урьдчилан сэргийлэх үүрэгтэй. Осол гарсан тохиолдолд нэн даруй мэдэгдэх ёстой.
- Хэрэв таны хийж буй ажилд хамгаалалтын хэрэгсэл шаардлагатай бол, хамгаалалтын хэрэгслээ өмсөх үүрэгтэй.

Хууль бус ажил гүйцэтгэх нь



- Европын Холбооны гишүүн бус гадаад иргэн та ажилтны үнэмлэхгүй, зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхлэх.
- Европын Холбооны гишүүн бус гадаад иргэн та хөдөлмөрийн зөвшөөрлөөр олгогдсон ажилтны үнэмлэхтэй зөрчилтэй хөдөлмөр эрхлэж байгаа бөгөөд шинэ гэрээ үүссэн эсвэл давхар ажил хийж байгаа байдлаа мэдэгдэн бүртгүүлээгүй тохиолдол.
- Европын Холбооны гишүүн бус гадаад иргэн та оршин суух зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхэлдэг бол.
- Европын Холбооны гишүүн бус гадаад иргэн та оршин суух бүх зөвшөөрлөө авсан боловч хөдөлмөрийн гэрээ тань хийгдээгүй байгаа бол (жишээ нь: туршилтын түр хугацаанд ажиллах)
- Шварц систем – хөдөлмөрийн гэрээний оронд үйл ажиллагааны тухай гэрээний дор бие даасан хувиараа хөдөлмөр эрхлэгч мэтээр ажиллаж буй дүр эсгэх. Хөдөлмөр эрхлэж буй үнэн байдал – дээд захирал тань таны ажил олгогч, таны ажлыг ажил олгогч тань хянан шалгах, ажил гүйцэтгэж буй газар тань ажил олгогчийн ажлын байран дээр явагдах. Эдгээр шинж тэмдэгтэй үйл ажиллагааны тухай гэрээн дор хөдөлмөр эрхлэх нь хууль бус ба шварц систем буюу хар систем гэж нэрлэдэг.

Хар системээр хөдөлмөр эрхлэж байгаа тохиолдолд ажил олгогч тань таны эрүүл мэндийн болон нийгмийн даатгал төлөхгүй байх магадлал өндөр. Энэ тохиолдолд та эрүүл мэндийн даатгалаа өөрөө төлөх шаардлагатай. Хар системээр хөдөлмөр эрхлэж байх хугацаандаа нийгмийн даатгалд хамрагдаагүй тохиолдолд ажилласан хугацаа тань тэтгэврийн даатгалд орохгүйг санаарай.

Хууль бусаар ажил гүйцэтгэж буй гадаад иргэнд хуулийн дагуу 100 000,- Kč хүртэлх торгууль оногдуулахаас гадна ажилтны үнэмлэх цуцлах арга хэмжээ авна. Ажил олгогч иргэнд хуулийн дагуу 10 000 000,- Kč хүртэл торгууль оногдуулж болно.

Танд зөвлөмж хэрэгтэй юу? Дараах албан байгууллагад хандаарай (холбоо барих хаягыг товхимолын сүүлийн хуудснаас хараарай)

OAMP – Височина аймгийн харьяа Дотоод хэргийн яамны Цагаачлал, шилжин сууршилтын бодлогын газар, Гадаадын иргэдийн оршин суух асуудал эрхэлсэн хэлтэс /Odbor azylové a migrační politiky, Oddělení pobytu cizinců Kraj Vysočina/

Ческа Бүдэзовицэ хотод суурьшилтай – Ийхоческий ба Височина аймгийн хөдөлмөр хяналтын газар/ Oblastní inspektorát práce pro Jihočeský kraj a Vysočinu se sídlem v Českých Budějovicích/

Височина аймгийн харьяа Гадаад иргэдийн дасан зохицох тусламжийн төв /Centrum na podporu integrace cizinců pro Kraj Vysočina/

5. Орон сууц



Чех улсад орон сууц хайж олох олон төрлийн арга байдаг. Энэ бүлэгт орон сууцны талаарх үндсэн ойлголтуудыг тайлбарлах болно.

Орон сууцтай холбоотой бүх бичиг баримт бодит байх ёстой! Жишээ нь оршин суух зөвшөөрлөө авахад танд байрны түрээсийн гэрээ хийгдсэн байх шаардлагатай.

Ерөнхий зарчим



- Шуудангийн хайрцаг болон хонхон дээр овог нэрээ бичих. Шуудангаа тогтмол шалгах.
- Хэрэв та нүүх гэж байгаа бол, шинэ оршин сууж буй хаягаа Дотоод хэргийн яамны – Цагаачлал, шилжин сууршилтын бодлогын газар/гадаадын цагдаад мэдэгдэх ёстой. Хэрэв шаардлагатай бол бусад байгууллагад хаяг өөрчлөгдсөн тухайгаа мөн адил мэдэгдэх нь зөв (жишээ нь банк, утасны оператор, урьдчилан захиалсан сэтгүүл сонин).
- Байрны журамтай танилцан мөрдөх (жишээ нь байрныхаа нийтийн хэсгүүдийг цэвэрлэх).
- Шөнийн амгалан тайван байдал 22:00 цагаас 6:00 цаг хүртэл баримтлах.

Түгээмэл нэр томъёо



Хувийн орон сууц

Орон сууц болон байшин худалдан авахад бүх бичиг баримттай байх нөхцөлтэй ба хувийн болгож авсан байраа үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэл дээр шилжүүлэн бүртгүүлэх хэрэгтэй.

Хувийн орон сууц худалдан авахад та өөрийн хуримтлуулсан хөрөнгөөр болон зардлын тодорхой хэсгийг банкаас байрны зээлээр санхүүжүүлэх боломжтой. Ипотек нь удаан хугацааны байрны зээл тул төлөн дуустлаа та эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгөөрөө батлан даах үүрэгтэй.

Түрээсийн орон сууц

Байрны эзэн үүнийг түрээсийн гэрээн дээр үндэслэн танд орон сууцаа ашиглуулан үлдээх зөвшөөрлөө гарын үсэг зуран баталгаажуулна. Гэрээ нь тодорхой дуусах хугацаатай ба хугацаа хязгааргүй гэсэн хоёр төрөл байж болно. Түрээсийн төлбөр нь түрээслэж эзэмшүүлсэн байрны төлбөрийг хэлнэ. Бусад үйлчилгээний төлбөр түрээсийн гэрээн дотор тусгагдсан ба тусгагдаагүй байж болно. Жишээ нь: цахилгааны, хогны төлбөр. Хэрэв гэрээн дотор эдгээр бусад төлбөрүүд ороогүй бол хэрхэн төлөх талаар эзэмшигчтэйгээ тохирох шаардлагатай.

Давхар түрээслэлийн орон сууц

Байрны түрээслэгч хүн байрны эзэнгийн зөвшөөрөл дээр үндэслэн түрээсний байрыг дахин дамжуулан түрээслүүлэхийг давхар түрээслэх гэж нэрлэдэг. Гэрээ нь тодорхой дуусах хугацаатай ба хугацаа хязгааргүй гэсэн хоёр төрөл байж болно. Түрээсийн төлбөр ба хэрэгцээгээр гарсан бусад төлбөрүүд дээрх дурьдсантай адил хэрэгжинэ.

Нийтийн байр

Богино хугацаагаар байрлахад тохиромжтой. Байрны эзэн танд ихэвчлэн нэг өрөө түрээслүүлэх ба нийтийн хэсгүүдийг өөрийн хэрэгцээгээр ашиглах боломжтой (гал тогоо, угаалгын өрөө...). Гэрээний заалт болон байрны дүрэм журам баримтлах нь таны үүрэг байх болно.

Барьцаа, батлан даалт

Түрээсийн гэрээ батлагдахаас өмнө урьдчилан төлөх мөнгөн барьцаа. Батлан даах барьцаа нь ихэвчлэн 1 – 3 сарын байрны төлбөр байдаг бөгөөд байрны төлбөрөө төлөх чадваргүй болох эсвэл түрээслэж буй байранд ямар нэгэн эвдрэл хохирол учруулсан тохиолдолд барьцааны мөнгөнөөс суутгах эрхтэй болно. Түрээсийн гэрээ цуцлагдсан тохиолдолд барьцаа мөнгө буцаан олгогдох ёстой. Барьцаа, батлан даалтыг түрээсийн гэрээнд оруулсан байх шаардлагагүй бөгөөд хэрэв урьдчилан өгсөн барьцаа мөнгөө төлсөн бол, төлбөрөө төлсөн батлагаа баримтаа авах хэрэгтэй.

Түрээсийн орон сууц хаанаас хайх вэ?

Юуны түрүүнд найз нөхөд болон ажлынхаа хамт олноосоо асуугаарай. Түүнээс гадна facebook дээрх нийтийн бүлэг дээр тавигдсан зар харах боломжтой. Хайлт дээр түрээсийн байр хайж буй хотынхоо нэрийг бичээрэй. Жишээ нь: bydlení Praha, pronájem bytu Jihlava гэх мэт. Хэрэв дээрх дурьдсан аргуудаар орон сууц олж чадаагүй бол интернэт хайлтын систем ашиглаарай (www.sreality.cz, www.bezrealitky.cz, www.bazos.cz гэх мэт). Хэрэв та агентлагаар байр хайлгуулахаар шийдсэн бол нэмэлт зуулчлалын төлбөр гарахыг бүү мартаарай.

Орон сууцны төрлүүд

Байр түрээслүүлэх зар дээр олон төрлийн тоо болон үсэг холбосон тэмдэглэлийг анзаарч хараарай. Эхний тоо нь өрөөний тоог илэрхийлнэ. Гал тогооны өрөө тусгай нэг өрөөнд тооцогдон +1 гэж тэмдэглэх эсвэл гал тогоо нь өөр өрөөтэй нийлсэн байршилийг КК гэж тэмдэглэсэн байдаг.

1кк 1 өрөө дотроо гал тогоо нь хамт байршилтай

1+1 1 өрөө + гал тогоо тусдаа байршилтай

2кк 2 өрөөний нэг нь гал тогооны өрөөтэй нийлсэн байршилтай

2+1 2 өрөө + гал тогоо тусдаа байршилтай



Танд зөвлөмж хэрэгтэй юу? Дараах албан байгууллагад хандаарай (холбоо барих хаягуудыг товхимолын сүүлийн хуудаснаас)

ОАМР – Височина аймгийн харьяа Дотоод хэргийн яамны Цагаачлал, шилжин сууршилтын бодлогын газар – Odborazylové a migrační politiky

Чех улсын цагдаагийн газар, Гадаадын харьяатын асуудал эрхэлсэн цагдаагийн байгууллага – Policie České republiky, Odbor cizinecké policie

Височина аймгийн харьяа Гадаад иргэдийн дасан зохицох тусламжийн төв – Centrum na podporu integrace cizinců pro Kraj Vysočina

6. Боловсрол



Чех улс нь хүүхэд, насанд хүрэгчдэд зориулсан өргөн боловсролын тогтолцоотой. Эдгээр нь төрийн, хувийн болон сүмийн боловсрол юм.

| | | |
|-------------------------|---|---|
| 6 сараас – 3 нас | ясли цэцэрлэг | сайн дурын төлбөртэй |
| 2 – 5 нас | цэцэрлэг | сайн дурын сарын төлбөртэй |
| 5 – 6 нас | цэцэрлэг | заавал эзэмших боловсрол төлбөргүй |
| 6 – 15 нас | бага сургууль, олон жилийн гимнази | заавал эзэмших боловсрол төлбөргүй |
| 15 – 19 нас | дунд сургууль, гимнази, мэргэжилд бэлтгэх дунд сургууль | заавал эзэмших боловсрол ихэнхдээ төлбөргүй |
| 19 дээш нас | мэргэжилд бэлтгэх дээд сургууль, дээд сургууль | заавал эзэмших боловсрол ихэнхдээ төлбөргүй |

Заавал эзэмших боловсролын дагуу улсын төлбөргүй цэцэрлэг, бага сургуульд сурч байгаа бол ихэнхдээ сургуулиас гадуур гарч буй зардлыг хувь хүн бүр тусдаа төлөх хэрэгтэй. Жишээ нь өдрийн хоолны төлбөр. Сургуулийн хэрэгсэл, аялалын төлбөр, театр үзэх, цанын ба усан сэлэлтийн нэмэлт хичээл гэх мэтчилэн онцгой нэмэлт зардлыг өөрсдөө төлнө.

Боловсрол ба Чех хэлний мэдлэгийн дутагдал



Чех хэлний мэдлэг дутагдалтай хүүхдүүд дараах тусламж авч болно:

- Бэлтгэл анги
- Нас үл харгалзан 2 жилээр улиран сурах
- Сургуулиас нэмэлт хичээл авах
- Сургуулийн чех хэлний дугуйланд хамрагдах
- Сайн дурын нэмэлт хичээл авах (сайн дурын төв, ашгийн бус байгууллага)
- Гадаад иргэдийн дасан зохицох тусламжийн төвөөс хэлний хичээл авах
- Ашгийн бус байгууллагаас чех хэлний хичээл авах

Хэрэв хүүхдээ оруулж буй сургуульд тань гадаад хүүхдүүд сургах туршлага байхгүй бол - Чех улсын Үндэсний сурган хүмүүжүүлэх байгууллагын мэргэжилтнүүдээс зөвлөгөө авна уу.



Бага сургуульд явагдаж буй бэлтгэл анги нь сайн дурын анги байдаг бөгөөд сургууль болгон бэлтгэл ангиар хангагдаагүй байдаг. Сургуулийн орчинд хүүхдийн дасан зохицох тал дээр тусладаг ба, хүүхдэд үндсэн ур чадвар ба сургууль дээр ажиллах системд сургадаг. 1 дүгээр ангид орохоос өмнө бэлтгэл ангидаа явах боломжтой. Бэлтгэл ангид явах хугацаанд хүүхэд чех хэлний анхан шатны мэдлэг авах ба 1 дүгээр ангид ороход сайн бэлтгэгдсэн байх болно.

Хэрэв хүүхэд сургууль дээрээ ямар нэгэн асуудалтай бол (унших, бичих, бодлого бодох, хүмүүжлийн асуудал) сурган хүмүүжүүлэх-сэтгэлзүйн зөвлөгөө өгдөг төвд хандаж болно. Төв дээр эцэг эх болон багшид хүүхэдтэй яаж харьцах талаар зөвлөгөө өгнө. 1 дүгээр ангид орохоос өмнө сурган хүмүүжүүлэх-сэтгэлзүйн төвд хандах шаардлагатай.

Хэрэв хүүхэд тань сургууль дээрээ ямар нэгэн асуудалтай бол, сургуулийн системийг ойлгохгүй байгаа бол сурган хүмүүжүүлэгч багшдаа эргэлзэлгүй хандаарай. Багш нар эцэг эхтэй харилцах туршлагатай ба таны хүсэлтийг дуртай хүлээн авна. Сургууль бүр тогтмол эцэг эхийн хурал хийдэг тул эцэг эхчүүд хуралдаа идэвхтэй оролцон, хүүхдийнхээ сургалтын явц болон хүмүүжил ааш араншингийн тал дээр анхаарал тавиарай.

Эдгээр бүх мэдээллийн талаар танд сурган хүмүүжүүлж байгаа багш өгөх болно. Хэрэв танд эцэг эхийн хурал дээр орчуулагч хэрэгтэй бол Гадаад иргэдийн дасан зохицох тусламжийн төвд хандаарай. Эсвэл сургуулийн зүгээс танд орчуулагч олгож болох ба Үндэсний сурган хүмүүжүүлэх байгууллагаас тэтгэгдэх тус орчуулгын бүх үйлчилгээ үнэ төлбөргүй байна.

Хэрэв хүүхэд тань ямар нэгэн хүндэтгэх асуудлаас болоод сургуульдаа явж чадахгүй бол сурч буй сургуулийнхаа дүрмийн дагуу чөлөөний хуудас ба хичээлээс чөлөө авах болсон шалтгаанаа бичгээр тайлбарласан хуудсаа өгөх ёстой.

Хүүхэд хичээлээ таслан, гадуур сэлгүүцэн явж байх үед Хотын цагдаагийн албан хаагч тухайн хүүхдийн бичиг баримтыг шалгах үүрэгтэй ба цагдаагийн албан хаагч тэмдэглэл үйлдэн Хүүхдийн нийгмийн болон хууль ёсны хамгааллын байгууллага болох OSPOD /Orgán sociálně právní ochrany dětí/-д хандах болно.

Хүүхдийн хичээл таслалтын тал дээр анхаарч, уг асуудлыг давтан гаргахгүй байх талаар эцэг эх, багшийн зүгээс хамтарсан арга хэмжээг авах нь зүйтэй.

Хүүхэд сургуульдаа явахгүй байгаа бол сургуулийн захиргаа болон Хүүхдийн нийгмийн болон хууль ёсны хамгааллын байгууллагаас эцэг эхтэй нь уулзан арга хэмжээ авах ёстой.

Хүүхэд чөлөөт цагаараа өөрийн сонирхож буй дугуйлан, дамжаанд хамрагдаж болох ба уг арга хэмжээг сургууль, Хүүхэд, залуучуудын төв, чөлөөт цаг өнгөрүүлэх олон төрлийн байгууллагууд эрхлэн явуулдаг.

Сургуулийн зуны амралтын үеэр хүүхдийн зуслангууд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ихэнхдээ төлбөртэй байдаг. Хүүхдийн зуслан нь бүтэн амралт шөнөдөө зуслан дээрээ хонох, хагас амралт шөнөдөө гэртээ хонох гэсэн 2 сонголттой.

Хүүхдийн нийгмийн болон хууль ёсны хамгааллын байгууллага OSPOD /Orgán sociálně právní ochrany dětí/



Уг байгууллага нь Хүүхдийн нийгэм, эрх зүйн хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг.

Уг байгууллагад та өөрийн биеэр хандаж болох бөгөөд гэр бүлийн салалт, гэрлэлтээ цуцлуулах тохиолдолд хүүхдийн нөхцөл байдлыг зохицуулах, хүүхдийн тэтгэмж олгох ба тогтоох, асран хүмүүжүүлэх асуудал дээр зөвлөгөө өгдөг.

Гэр бүл цуцлуулах үйл явцын үеэр уг байгууллагыг хүүхдийн асран хамгаалагчаар томилж болно.

Уг байгууллага нь шүүхийн өмнө хүүхдийн эрх ашгийн өмнөөс төлөөлөн оролцох бөгөөд тэтгэмж тогтоох, хүүхдийг эцэг эхийн хэн нь өөрийн асрамжиндаа авах, эцэг эх хэрхэн хүүхдээ эргэх, авах тал дээр санал дэвшүүлдэг.

Хүүхдийн нийгмийн болон хууль ёсны хамгааллын байгууллага нь хотын захиргааны байгууллагын харьяа байгууллага юм. Холбогдох мэдээллийг вэб сайтаас авна уу.



Сургууль, хөрш айл эсвэл бусад хүмүүсийн зүгээс хүүхдийн суралцах эрхийг зөрчсөн, хүүхдийг хүчирхийлсэн, хүүхдийн эрх чөлөөнд халдсан зэрэг сэжигтэй асуудал илэрвэл уг байгууллагад хандах бөгөөд байгууллагаас хүүхдийн асран хамгаалагчтай холбогдоно.

Байгууллагын зүгээс эцэг эх, хүүхдэд дараах урьдчилсан арга хэмжээг авна. Үүнд:

- Сануулах
- Хүүхдийн хүмүүжилд хяналт тавих
- Эцэг эх, хүүхэд, гэр бүлд зөвлөгөө өгөх газар луу томилон явуул

Түүнчлэн Хүүхдийн нийгмийн болон хууль ёсны хамгааллын байгууллага нь хүүхдийг түр хугацаанд гэр бүлээс нь тусгаарлан байрлуулах асуудлаар шүүхийн газарт өргөдөл өгч болно.



Боловсролын нострификацэ



Та эх орондоо их, дээд сургуулийн боловсрол эзэмшсэн бол өөрийн гэрчилгээгээ Чех улсын холбогдох байгууллагаар дүйцүүлэн тодорхойлолт гаргуулах эрхтэй. Уг тодорхойлолтыг авахдаа:

- Диплом, гэрчилгээгээ албан ёсоор баталгаажуулсан хуулбар.
- Хичээлийн жагсаалт, дүнгийн жагсаалтаа авчрах шаардлагатай.

Энэхүү 2 баримтаа албан ёсны шүүхийн орчуулагчаар Чех хэл дээр дугуй тамгатай орчуулуулсан байх ёстой. Төгссөн их, дээд сургууль, мэргэжлээс тань хамааран Чех улсад түүнтэй адил төрлийн сургууль таны хүсэлтийг шалгасны үндсэн дээр бүтэн хүлээн зөвшөөрсөн, хагас хүлээн зөвшөөрсөн, хүлээн зөвшөөрөөгүй гэсэн шийдвэрийн аль нэгийг гаргах ба гэрчилгээ дүйцүүлэн олгох тодорхойлолт нь төлбөртэй байдаг.

Бага, дунд болон мэргэжилд бэлтгэх сургуулиудын гэрчилгээг дүйцүүлэх тодорхойлолт авахын тулд дээр дурдсан нөхцлүүдийг хангах шаардлагатай бөгөөд бүрдүүлсэн бичиг баримтаа Височина аймгийн Боловсролын хэлтэст өгнө.

Танд зөвлөмж хэрэгтэй юу?

Височина аймгийн харьяа Аймгийн захиргаа байгууллага /Krajský úřad Kraje Vysočina/
Височина аймгийн харьяа Гадаад иргэдийн дасан зохицох тусламжийн төв /Centrum na podporu integrace cizinců pro Kraj Vysočina/
FPOINT, z. s.

7. Амралт чөлөөт цаг



Височина аймагт үнэ төлбөртэй болон төлбөргүйгээр амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжтой газрууд олон байдаг.

Хөшөө дурсгалууд, аялах боломжтой газруудын талаар зэрэг вэб сайтаас мэдээлэл авах боломжтой.



www.kudyznudy.cz/kam-pojedete/vysocina

QR код татан суулгах програмын /апликац/ заавар товхимлын сүүлийн хуудаснаас хараарай.



Чех улс ба Височина аймаг нь өргөн хүрээний дугуйчдын замтай ба хэрэв танд дугуй байдаг бол Nejtější databáze cyklotras v České Republice гэж бичиж хайгаад өөртөө тохирсон замынхаа түвшинг сонгоорой.



cestujnakole.cz/cs


QR код татан суулгах програмын /апликац/ заавар товхимлын сүүлийн хуудаснаас хараарай.

Височина аймагт явган аялал хийхэд их тохиромжтой. Чех Улс дахь явган аялал жуулчлалын клубууд нь явган замын тэмдэглэл дээр олон жилээр анхаарал тавьж ирсэн. Эхлэх замаа тэмдэглэсний дараа аялалын маршрутаа эндээс төлөвлөн хараарай.



trasy.kct.cz

QR код татан суулгах програмын /апликац/ заавар товхимлын сүүлийн хуудаснаас хараарай.



Замын зүг чигийг заасан сум нь шар, ногоон, цэнхэр ба улаан гэсэн 4 төрлийн өнгөөр тэмдэглэгдсэн байдаг. Та амралт чөлөөт цагаа спортын талбай, кино театр, бусад үзвэрийн газруудаар өнгөрөөх боломжтой.

Спортын талбай болон бусад газруудын жагсаалтыг хотынхоо вэб сайт дээрээс харах боломжтой, эсвэл www.mapy.cz хаягаар орж „SPORTOVISTĚ” гэж бичээрэй. Спортын төв газруудын хаягыг товхимолын сүүлийн хуудаснаас хараарай.



Театр, кино, бусад соёлын арга хэмжээний хөтөлбөрийг мөн адил хотуудын вэб сайтаас эсвэл эндээс харах боломжтой.

www.informuji.cz

QR код татан суулгах програмын /апликац/ заавар товхимлын сүүлийн хуудаснаас хараарай.

Мөн Височина аймагт UNESCO-д бүртгэгдсэн дэлхийн соёлын болон байгалийн өвийн дурсгалт газрууд (Telč, Třebíč, Žd'ár nad Sázavou) байдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг вэб сайтаас аваарай.



www.unesco-czech.cz

QR код татан суулгах програмын /апликац/ заавар товхимлын сүүлийн хуудаснаас хараарай.

8. Аюулгүй байдал



Чех Улсын хууль дүрэм нь таны эх орондоо дасан зохицсон хууль дүрмээс өөр байж магадгүй боловч та энэ улсад ажиллаж, амьдарч байгаа бол Чех Улсад батлагдсан хууль дүрмийг мөрдөж түүнийг биелүүлэх үүрэгтэй. Аюулгүй байдлын талаарх үндсэн тоймыг доор тусгасан байгаа.

Автомашин барих



Жолоо барих үндсэн дүрэм

- Жолооны ард ядрахаас сэргэмжлэх, удаан хугацаагаар жолоо барих тохиолдолд олон удаа завсарлага авах хэрэгтэй.
- Замын хөдөлгөөний зөрчил, гэмт хэргийг оноо олгох ба хасах системээр тэмдэглэн торгууль ногдуулдаг. Хэрэв та жилийн дотор 12 удаа торгуулийн оноо авсан тохиолдолд жолооны үнэмлэхээ хураалгана. Үнэмлэхээ эргүүлэн авах хүсэлтээ жилийн дараа өгөх эрхтэй.



Замын хөдөлгөөний зөрчил, гэмт хэргийн жагсаалын мэдээллийг-
informativní přehled bodového hodnocení | TSB хаягнаас хараарай.



www.tymbezpecnosti.cz/stranky/102/about-us.html

QR код татан суулгах програмын /апликац/ заавар товхимлын сүүлийн хуудаснаас хараарай.

Автомашин жолоодох эрхийг 18 нас хүрсэн, хугацаа нь хүчинтэй жолооны үнэмлэх эзэмшсэн хүн эдэлнэ. Тээврийн асуудал хариуцсан байгууллага дээр танд гадаад иргэний жолооны үнэмлэх хэрхэн зөвшөөрөх тал дээр мэдээлэл өгөх болно. Хэрэв та жолоо барих эрхгүй бол, жолооны курсэд хандана уу. Жолооны курсын жагсаалтыг эндээс олж хараарай – Бүх жолооны курсүүд үнэ төлбөртэй.



www.vsechny-autoskoly.cz/autoskoly

QR код татан суулгах програмын /апликац/ заавар товхимлын сүүлийн хуудаснаас хараарай.

- Чех Улсад архи согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдолд жолоо барих хориотой бөгөөд цагдаа таны согтуурлын хэмжээг тогтоох зорилгоор тестээр шалгах эрхтэй. Хэрэв та шалгуулахаас татгалзвал хууль зөрчсөн ноцтой асуудал болох ба жолоо барихыг хориглох мөн 7 хүртэл оноо хасах арга хэмжээг авна.
- Мансууруулах бодис хэрэглэсэн тохиолдолд жолоо барих хатуу хориотой бөгөөд цагдаа таныг мансууруулах бодис хэрэглэсэн эсхийг шалган тест авах эрхтэй.
- Жолоо барьж байхдаа жолооны үнэмлэх, автомашины даатгалд хамрагдсан баримт өөрөөр хэлбэл жижиг техникийн үнэмлэхийг байнга машиндаа авч явах шаардлагатай.

Явган зам дээрх хөдөлгөөн



- Явганаар замын хөдөлгөөнд оролцохдоо явган хүний гарцаар зам хөндлөн гарна уу. Хэрэв явган хүний зам аль ч талд байхгүй тохиолдолд замын зүүн талаа барьж явах нь зүйтэй.
- Явган хүний гарцаар гарах үедээ та анхааралтай байж 2 урсгалаас хоёуланд нь автомашин зам тавин зогсол хүлээх хэрэгтэй.
- Бороо цас орсон, манан татсан, шөнийн цагаар гэх мэт цаг агаарын нөхцөл байдлаас болж үзэгдэх орчин муу болсон тохиолдолд та гэрэл цацруулагч ашиглах шаардлагатай. Мөн нийтийн гэрэлтүүлэггүй замаар явахад орчны харагдах байдал гадны нөлөөнөөс болж буурсан тохиолдолд та гэрэл цацруулагч заавал зүүх үүрэгтэй.

Гэмт хэрэг ба эрүүгийн гэмт хэрэг



Чех улсын хууль тогтоомж болон орон нутгийн дүрэм, журам зөрчсөн үйлдэл нь гэмт хэрэг эсвэл эрүүгийн гэмт хэрэгт тооцогдоно. Чех улсын хууль тогтоомжид гэмт хэрэг эсвэл эрүүгийн гэмт хэрэг гэж тодорхой нэрлэсэн заалт байхгүй бөгөөд гарсан зөрчлийг нийтэд нь авч үзэх, хувь хүний урьд үйлдэж байсан эрүүгийн гэмт хэргийн бүртгэл ба бусад нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр шийдвэрийг гаргадаг.

Европын холбооны орноос бусад орны иргэдийн хувьд гэмт хэрэг үйлдсэн зөрчил илэрсэн тохиолдолд тухайн иргэний Чех улсад оршин суух зөвшөөрөлд шууд нөлөөлдөг.

Хэрэв та санаатай гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр батлагдан ял оноосон тохиолдолд таны ажлын виз шууд цуцлагдана. Бусад төрлийн визний хувьд дээр дурдсан хуулийн заалт адил үйлчлэх болно.

Чех улсын болон орон нутгийн цагдаагийн эрх



Чех улсын болон орон нутгийн цагдаа нь нийтийн хэв журам, дэглэм, иргэдийн аюулгүй байдал, эд хөрөнгийг хамгаалан хяналт тавих, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй. Үүргээ биелүүлэхийн тулд дор дурдсан эрхийг эдэлнэ.

- Бичиг баримт шалган шаардах.
- Бусдыг хэл амаар доромжилсон, хүний эд хөрөнгөнд халдан хохирол учруулсан зөрчил нь үйлдэл дээрээ баригдсан хүнийг баривчлан хорих.
- Тээврийн хэрэгсэл жолоодож яваа жолоочийг түр зогсоон жолоодох эрхийн үнэмлэх, зөвшөөрлийг шалгах.
- Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалган тест хийх.
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг 10 хоногоор баривчлах.
- Зам, тээврийн хөдөлгөөнийг хянах, хязгаарлах.

Орон нутгийн цагдаа нь харьяа хот дотроо үйл ажиллагаагаа явуулах бөгөөд иргэдийн аюулгүй байдал, эд хөрөнгийг хамгаалах, нийтийн амгалан тайван байдлыг хангуулах, хяналт тавих (жишээ: шөнийн амгалан тайван байдлыг алдагдуулах гэх мэт) болон хотын захиргааны дүрэм журмыг дагаж мөрдөх (жишээ: хууль тогтоомжоор хориглосон газарт архи, согтууруулах ундаа хэрэглэх гэх мэт) зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Албадан хөдөлмөр эрхлэх ба хөдөлмөрийн мөлжлөг



Албадан хөдөлмөр эрхлүүлэх, биеийг нь үнэлүүлэх, бэлгийн мөлжлөг, хүчээр гэрлүүлэх гэх мэт нь хүний наймааны төрөлд хамаарна. Биеэ үнэлэлт нь хөдөө аж ахуй, барилга болон гэрийн ажил (хүүхэд, ахмад настан асрах, гэр цэвэрлэгээний ажил) гэх мэт салбарт ихэвчлэн явагддаг.

Хүн наймаалахад хүний нас, хүйс үл хамаарна. Чех улсад хүний наймааны асуудлыг хууль бус гэж үздэг бөгөөд хууль тогтоомжоор хориглосон байдаг.

Хүний наймааны нийтлэг шинж тэмдэг:

- Чех улсад ирэхэд ажлын гэрээнд зааснаас өөр газар, өөр ажил хийлгэх
- Ажил олгогч таны гадаад паспорт, бусад бичиг баримтыг хураан авах
- Хөдөлмөр эрхэлж буй хүний эрхэнд халдан сүрдүүлэх, сэтгэл санаа болон биеийн хямралд оруулах
- Илүү цагаар ажиллуулах, амралт, чөлөө авах эрхийг хязгаарлах
- Ажлын байр ба амьдарч буй газраасаа гарахыг хориглох.
- Ажилласан цагийн цалин хөлсийг хууль тогтоомжид заасан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур бодож олгох эсвэл цалинг нь олгохгүй байх. (Ажилтныг хууль тогтоомжид заасан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалинжуулж байгаа шалтгаанаа ажил олж өгсний хөлс, ажлын гүйцэтгэл муу байсан гэх мэтээр тайлбарладаг.)

Таны эргэн тойронд албадан хөдөлмөр эрхлүүлж буй сажигтэй тохиолдол илэрвэл энэхүү хууль бус үйлдлийг Чех улсын аль ч хотын цагдаагийн газарт мэдэгдэж болно.

Хэрэв танд тусламж хэрэгтэй бол:

La Strada, O.P.S байгууллагын <http://www.pomoc@strada.cz> вэб сайт, 222 71 71 71 болон 800 07 77 77 дугаарын утсаар холбогдох Височина аймгийн харьяа Гадаад иргэдийн дасан зохицох тусламжийн төв /Centrum na podporu integrace cizincu pro Kraj Vysočina/

Түгээмэл хөнгөн гэмт хэргүүд



Шөнийн амгалан тайван байдлыг алдагдуулах:

Чех улс даяар шөнийн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл хугацаанд шөнийн амгалан байдал тогтоосон байдаг бөгөөд та энэ хугацаанд өөрийн ойр тойрны иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байхыг хичээх хэрэгтэй.

